

Сургуулиас түр чөлөөлөх хугацааг сунгах тухай мэдэгдэл

Утсан орчуулгын үйлчилгээг ашиглан сургуультай холбогдох нь

Сурагчийн нэр
Name of student

Эрхэм хүндэт эцэг эх/асран хамгаалагч танаа

Хавсаргасан захидалд NSW мужийн Боловсролын Яамны Сурагчийн Зан Авирын Тухай Бодлого, мөн Сургуулиас Түр Чөлөөлөх болон Хөөх Журмын дагуу таны хүүхдэд өгсөн сургуулиас түр чөлөөлөх хугацааг сунгах тухай мэдэгдлийн дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан болно.

Уг захидалд сургуулиас түр чөлөөлөх мэдэгдлийн шинэ дуусах огноог зааж өгсөн бөгөөд сургуулиас түр чөлөөлөх тухай, түүнчлэн таны хүүхдийг сургуульдаа буцаж ирж суралцахад дэмжлэг үзүүлэх төлөвлөгөө зэргийг хэлэлцэх шийдвэрлэх хуралд таныг оролцохыг урьж байна. Сургууль тантай холбогдоход уулзалтын үеэр орчуулагч хэрэгтэй эсэхийг мэдэгдэнэ үү. Бид үүнийг зохицуулах болно. Хэрэв танд хавсаргасан захидлыг ойлгоход хүндрэлтэй байвал сургуультай холбоо барина уу. Бид танд тайлбарлаж өгөх болно.

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.

Захирлын нэр
Name of Principal

Захирлын утасны дугаар
Principal's phone number